



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 9/44

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит IX хуралдааныг 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 09:00 цагт Эрдэнэт хотод зарлан хуралдуулсугай.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IX хуралдааны илтгэл, илтгэгчийг нэгдүгээр хавсралтаар, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн
0/44 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААНЫ
ИЛТГЭЛ, ИЛТГЭГЧ

1. Эрдэнэт хотын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

2. Аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ХХААГ-ын дарга Ж.Бат-Өлзий

3. “Сангийн журам” батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга М.Мөнхбаяр

4. Иргэдийн шаардлага, Төлөөлөгчдийн саналыг танилцуулах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг хэлэлцэх тухай

Илтгэгч нь: Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга С.Даваадорж

6. Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга С.Батжаргал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн
А/44 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн ИТХ-ын Ээлжит IX хуралдааны бэлтгэл хангасан дүнг Хурлын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, илтгэл илтгэгчийг батлах.

IV/26-нд

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IX хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах

IV/27-ны дотор

Хурлын Зөвлөл

3. Хороод холбогдох чиглэлээр санал дүгнэлт гаргаж Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх.

IV/29, V/03 -ны дотор

Хороодын дарга нар

4. Аймгийн ИТХ-ын Ээлжит IX хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгааны материал, гарах шийдвэрийн төслийн хамт Ажлын албанд ирүүлэх, Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх.

IV/27, IV/29-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5. Төлөөлөгчид тойрогтоо ажиллах, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд тусгуулах санал асуудлыг нэгтгэж, Ажлын албанд ирүүлэх.

Бэлтгэл ажлын явцад

Төлөөлөгчид

6. Хуралдааны техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах.

V/03-ны дотор

Ажлын алба

ХУРЛЫН ЗӨВЛӨЛ